



## **ЭРДЭНИЙН БАТ-ҮҮЛ**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч  
2012.08.11 сараас одоо хүртэл

Улаанбаатар хотод Ардын Уран зохиолч С.Эрдэнийн хүү болон 1957 оны дол дугаар сарын 1-нд төрсөн. 1975 онд Улаанбаатар хотын 1 дүгээр сургууль, 1981 онд Монгол Улсын Их Сургуулийг физикч мэргэжлээр төгссөн. Тэрбээр 1981-1982 онд Барилгын техник мэргэжлийн сургуульд багшаар ажиллаж байгаад 1982-1985 онд өөрийн хүсэлтээр Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын 10 жилийн дунд сургуульд багшаар томилогдон ажиллаж байв. 1985-1989 онд Шинжлэх ухааны академид эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байсан.

1990 онд Монголын Ардчилсан Намыг анх байгуулалцаж, анхных нь даргаар сонгогдон 1992 он хүртэл ажиллаж байлаа. Тэрбээр 1990-1992 онд Ардын Их Хурлын депутат, 1992-1996 онд Монголын Ардчилсан Намын улс төрийн судалгааны хүрээлэнгийн захирал, Монголын Үндэсний Ардчилсан Намын Ерөнхий нарийн бичгийн дарга, дэд даргаар ажиллаж байгаад 1996-2000 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байв.

2000-2004 онд Чугу ХХК-д ажиллаж байгаад 2004, 2008 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр дахин сонгогдож 8 жил ажилласан.

2009 онд Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойгоор Монгол Улсын баатар цолоор шагнуулсан.

2012 оны Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Ардчилсан Намын жагсаалтыг тэргүүлэн оролцож намдаа ялалт авчирсан бөгөөд 2012 оны 8 сарын 7-ноос Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн албыг хашиж байна.